



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А-196

Улаанбаатар хот

Ц.Төмөрбаатарыг албан томилолтоор  
ажиллуулах тухай


Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.8 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах “Уул уурхайн-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, паркийн дэд бүтцийн төлөвлөлт болон техник эдийн засгийн үндэслэлд заагдсан үйлдвэрийг барьж байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын байгуулсан ажлын хэсэгт Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Төмөрбаатарыг 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 4 хоногийн хугацаатай албан томилолтоор ажиллуулсугай.

2. Томилолтын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Томилолтын зардалд шаардагдах 207,000 /Хоёр зуун долоон мянга/ төгрөгийг яамны дотоод томилолтын зардлаас санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Ө.Мандухай/-д зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажилласан тайланг ирснээс хойш ажлын 5 өдөрт танилцуулахыг Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Ц.Төмөрбаатарт үүрэг болгосугай.



00000770